




# ИНФОГРАФИК /1 ДҮГЭЭР САР/

## 1.ИНФЛЯЦИ

Жилийн инфляци 2016 оны 01 дүгээр сард улсын хэмжээнд 1,7 хувь, Улаанбаатар хотод 1,0 хувьтай байна.


Суурь инфляци 01 дүгээр сарын байдлаар жилийн 4,0 хувь байна.




## 2.МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Мөнгөний нийлүүлэлт 2016 оны 01 дүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 199,4 тэрбум төгрөгөөр буюу 2,0%-иар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 463,8 тэрбум төгрөгөөр буюу 4,7%-иар буурч 9850,8 тэрбум төгрөг байна.

Мөнгөний нийлүүлэлт /тэрбум төг/




Мөнгөний нийлүүлэлт /жилийн өсөлт/



## 3.ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН АЛБАН НӨӨЦ


Гадаад валютын улсын албан нөөц /тэрбум ам.доллар/



2015 оны 12 дугаар сарын байдлаар гадаад валютын албан нөөц 1,32 тэрбум ам.доллар болж өмнөх сараас 9,30%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 19,81%-иар тус тус буурчээ.


#### 4. ХАДГАЛАМЖ

Нийт хадгаламж 01 дүгээр сарын байдлаар 7297 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 3,48%-иар буурчээ. Үүнээс төгрөгийн хадгаламж 5312 тэрбум төгрөгт хүрч өмнөх сараас 2.2%-иар буюу 121,5 тэрбум төгрөгөөр буурсан, өмнөх оны мөн үеийнхээс 52,04 тэрбум төгрөг буюу 0,97%-иар буурсан үзүүлэлттэй байна.




#### 5. ЗЭЭЛ

2016 оны 01 дүгээр сарын эцэст нийт зээлийн өрийн үлдэгдэл 11783 тэрбум төгрөгт хүрч өмнөх сарынхаас 87,2 тэрбум төгрөгөөр буюу 0,7 хувиар өссөн ба өмнөх оны мөн үеийнхээс 305,8 тэрбум төгрөгөөр буюу 2,5 хувиар буурсан байна.



Нийт зээлийн 7,59 хувийг чанаргүй зээл эзэлж байна.



## 6. ГҮЙЛГЭЭНД ГАРГАСАН БЭЛЭН МӨНГӨ



2016 оны 01 дүгээр сарын эцэст гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 713,8 тэрбум төгрөг болж өмнөх сараас 7,1 тэрбум төгрөгөөр буюу 1,00%-иар өсч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 18,6 тэрбум төгрөгөөр буюу 2,54 %-иар буурчээ.

## 7. ГАДААД ДОТООД ЦЭВЭР АКТИВ

Гадаад цэвэр актив өмнөх сараас 307,4 тэрбум төгрөгөөр буюу 7,9 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 2076 тэрбум төгрөгөөр буюу 97 хувиар буурч -4216,3 тэрбум төгрөг болов.



## 8. ХУДАЛДАН АВСАН АЛТНЫ ХЭМЖЭЭ, КГ



2015/1 сар	480,1 кг
2015/2 сар	218,4 кг
2015/3 сар	287,0 кг
2015/4сар	536,7 кг
2015/5сар	895,4 кг
2015/6 сар	1344,1 кг
2015/7 сар	1647,6 кг
2015/8 сар	1993,8 кг
2015/9 сар	2793,5 кг
2015/10 сар	2674,0 кг
2015/11 сар	1518,4 кг
2015/12 сар	694,8 кг
2016/01 сар	644,1 кг